

GOBI

MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г

Хурлын ирцийн тухай

Г

Говь ХК-ийн 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг хурлын даргад мэдээлэх нь:

Нэг. Говь ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдөр нь 2024 оны 04-р сарын 10-ны өдөр байсныг дурдсугай.

Хоёр. Бүртгэлийн өдрөөр Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо **780,112,500** ширхэг байснаас хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх арга хэлбэрээр **12,462,706 (1.60%)** саналын эрхтэй **629** хувьцаа эзэмшигч, 04-р сарын 29-ний өдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр **678,761,381 (87.01%)** саналын эрхтэй **74** хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт ирц **88.61** хувь болж, хурлын ирц бүрдсэнийг мэдэгдсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ГИШҮҮД



[Signature]

Н.САЙНЗУЛ

Ц.ЦЭЦЭГБАДАМ

Б.УЯНГА

Д.САРАНГУА

Б.НОМИН

Г.УУГАНЗАЯА

[Signature]

[Signature]

[Signature]

[Signature]

[Signature]



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Санал хураалтын нэгтгэсэн дүнгийн тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3, Говь ХК-ийн дүрмийн 6.1.10-6.1.16 заалтыг удирдлага болгон 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Нийт **88.61** хувийн саналын эрхтэй **691,220,958** ширхэг хувьцааны **697** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.

Хоёр. 2024 оны 04-р сарын 29-ний өдөр санал хураах хайрцгаар **87.01** хувийн саналын эрхтэй **678,754,652** ширхэг хувьцааны **68** ширхэг саналын хуудас хураасныг дурдсугай.

Гурав. Урьдчилж ирүүлсэн саналын хуудасны хувьд шуудангаар дамжуулж **0.00** хувийн саналын эрхтэй **7,000** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас, үнэт цаасны компаниар дамжуулж **1.55** хувийн саналын эрхтэй **12,099,235** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас, компанийн байранд **0.05** хувийн саналын эрхтэй **360,071** ширхэг хувьцааны **627** ширхэг саналын хуудас тус тус урьдчилж ирүүлснийг дурдсугай.

Дөрөв. Нийт саналын хуудаснаас **0.01** хувийн саналын эрхтэй **93,469** ширхэг хувьцааны **50** ширхэг саналын хуудас хүчингүй болсныг дурдсугай.

Тав. Говь ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Зургаа. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Долоо. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны цалингийн төсвийг батлах тухай асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Найм. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус болон ердийн гишүүдийг сонгох асуудлаар хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг кумулятив аргаар тоолж, хамгийн олон санал авсан 9 гишүүдийг сонгон томилсныг мэдэгдсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ГИШҮҮД



[Handwritten signature]

Н.САЙНЗУЛ

[Handwritten signature]

Ц.ЦЭЦЭГБАДАМ

[Handwritten signature]

Б.УЯНГА

[Handwritten signature]

Д.САРАНГУА

[Handwritten signature]

Б.НОМИН

[Handwritten signature]

Г.УУГАНЗАЯА

GOBI

MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон 7
санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг
батлах тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА



ГОВЬ ХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол улсын Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд Говь ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг 2024 оны 01-р сарын 26-ны ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

ТУЗ нь 2023 оны эхний хурал дээр тус компанийн 2023 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтыг хэлэлцэн баталж, хэрэгжилт дээр нь тогтмол хяналтыг тавин, компанийн Гүйцэтгэх удирдлагын багийг санал зөвлөмж, үүрэг даалгавраар ханган чиглүүлж ажилласан бөгөөд Гүйцэтгэх удирдлагын баг нь ТУЗ-ийн баталсан төлөвлөгөө зорилт, шийдвэр, санал зөвлөмж, үүрэг даалгаврыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

ТУЗ-ийн баталсан 2023 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь компанийн борлуулалтын орлогыг өмнөх оноос 69% өсгөх, ашигт ажиллагааг сайжруулан бохир ашгийн түвшнийг 49%-д барих, гадаад зах зээлийн борлуулалтын сувгийг нэмэгдүүлэн хэрэглэгчдэд илүү ойртож ажиллах, SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж Говь брэндийн органик хайлтыг сайжруулах, программ хангамж болон удирдлагын системийг хөгжүүлж Product Lifecycle Management (PLM) системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын соёлыг сайжруулах, хүний нөөцийг тогтворжуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хүний нөөцийн эргэцийг бууруулах, олон улсын туршлагатай загвар зохион бүтээгчтэй хамтарч ажиллан бүтээгдэхүүний загвар дизайн, өмсгөл суултыг сайжруулах, 1 сая бүтээгдэхүүн үйлдвэрлэн, чанарын үзүүлэлтийг сайжруулах зэрэгт тус тус чиглэсэн билээ.

Санхүүгийн үр дүнгийн хувьд өнгөрөгч 2023 онд 255.7 тэрбум төгрөг буюу түүхэндээ хамгийн өндөр борлуулалттай ажилласан бөгөөд бизнес төлөвлөгөөний биелэлт 78%-ийн гүйцэтгэлтэй буюу өмнөх оноос 32% өссөн үзүүлэлттэй гарлаа. Дотоод борлуулалт 147.0 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 90% буюу өмнөх оноос 57% өссөн, гадаад борлуулалт 49.2 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 48% буюу өмнөх оноос 10% буурсан, экспортын борлуулалт 59.5 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 97% буюу өмнөх оноос 30% өсжээ. Энэ онд өмнөх онтой харьцуулахад алдагдлын хэмжээг 44% бууруулж 3.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд бохир ашгийн түвшнийг зорилтот түвшинд буюу 49%-д барьж чадлаа. Мөн түүхий эд татан авалтыг хамгийн бага түвшинд хийж, нөөцийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бараа материалын эргэцийг 24% бууруулж чадсан байна.

Үйлдвэрлэлийн хувьд 2023 онд 1 сая бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь төлөвлөгөөний биелэлт 100% буюу өмнөх оноос 23% өссөн бөгөөд бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт 92% болж өмнөх оноос 1% өссөн. Мөн өнгөрөгч онд 1.2 сая ширхэг бүтээгдэхүүн борлуулж төлөвлөгөөний биелэлт 83% буюу өмнөх оноос 14%-ийн өсөлтийг үзүүлсэн. Бид үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор орон нутаг дахь анхны салбар үйлдвэрээ Хэнтий аймагт байгуулж 100 гаруй ажлын байрыг шинээр бий болгон хөдөө орон нутгийн ажлын байрыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр орууллаа.

Борлуулалтын зах зээлүүдийн хувьд Монгол Улсад зочлох жуулчдын тоо нэмэгдсэн нь компанийн дотоод зах зээлийн борлуулалтын орлого нэмэгдэхэд гол нөлөөг үзүүлсэн бол экспортын зах зээлд цөөн бөгөөд чанартай стратегийн харилцагчидтай хамтран ажиллах бодлогыг баримталж ажилласны дүнд ашигт ажиллагаа болон үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөг үзүүлж чадсан.

Мөн гадаад зах зээлийн борлуулалтын хувьд дэлхийн геополитикийн хурцадмал байдал, дэлхийн эдийн засгийн удаашрал болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө багагүй байсан хэдий ч Гүйцэтгэх удирдлагын багийн зүгээс шат дараатай алхмуудыг авч, хэрэгжүүлэн ажилласан билээ. Үүнээс онцлон дурдвал борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Казахстан Улсад охин компани байгуулж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Дюссельдорф хотод шинэ салбар дэлгүүр нээсэн бөгөөд Говь брэндийн органик хайлтыг сайжруулах зорилгоор SEO компаниудтай хамтран ажилласны үр дүнд www.gobicashmere.com вебсайт руу хандсан нийт хандалтаас органик хандалт 38%-ийн өсөлтийг үзүүлсэн амжилттай байна.

Компанийн программ хангамж болон удирдлагын системийг хөгжүүлэх зорилтын хүрээнд SAP ERP систем, PLM систем ба бэлэн бүтээгдэхүүн бүртгэл тооллогын систем зэрэг үйлдвэрлэлийн шат дамжлага, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн системүүдийг шат дараалан үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд энэ нь бизнесийн үйл ажиллагааг автоматжуулж, үйл явцыг хурдлуулах төдийгүй бүтээмжийг нэмэгдүүлэхэд томоохон дэвшил авчрах юм.

Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн процессууд дээр байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх ажлуудыг хийсээр ирсэн бөгөөд энэ онд манай компанийн усны хэрэглээг бууруулах, хэмнэлттэй хэрэглэх зорилгоор авч хэрэгжүүлсэн ажлууд үнэлэгдэн “Тогтвортой ноолуурын өдөр – 2023” арга хэмжээний хүрээнд “Усны зохистой хэрэглээг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шилдэг байгууллага”-аар шалгарсан. Мөн “CSR Awards 2023” арга хэмжээний үеэр бидний 2020 оноос хойш хэрэгжүүлж буй “Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл” нийгмийн хариуцлагын чиглэлийн төслүүдээс шалгарч “Тогтвортой хөгжлийн шилдэг төсөл” шагналыг хүртсэн.

Өнгөрөгч оны онцлох үйл явдлуудын нэг нь тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг дэмжих, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор Азийн Хөгжлийн Банктай 30 сая ам.долларын санхүүжилтийн гэрээг амжилттай үзэглэж, эхний санхүүжилтээ хүлээн авсан явдал бөгөөд цаашид тогтвортой хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтыг тасралтгүй нэмэгдүүлэхээр зорьж байна.

Мөн ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны стандартын баталгаажуулалтыг авч, 2022 онд авсан ISO 14001, ISO 45001 стандартуудын магадлан аудитыг хамгаалж, гэрчилгээний хугацааг сунгаснаар Нэгдсэн удирдлагын тогтолцоог цогцоор нь хэрэгжүүлэгч компани болж чадлаа.

Байгууллагын соёлыг сайжруулах зорилгоор ажлын байрны таатай орчныг бүрдүүлэн, гүйцэтгэлд суурилсан цалин хөлс, урамшууллын бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж цалинг үе шаттайгаар нэмэгдүүлсний үр дүнд дунджаар 24% өсгөв. “Аз жаргалтай ажилтан” зорилтын хүрээнд ажил амьдралын тэнцвэрт байдлыг бүрдүүлэхээр ажлын уян хатан цагийн системийг оффисын ажилтнуудад, богиносгосон цагийн системийг нярай болон

цэцэрлэгийн насны хүүхэдтэй үйлдвэрийн ажилтнуудад хэрэгжүүлж эхэлсэн ба байгууллагын дэргэдэх цэцэрлэгийг зуны улирлын туршид тасралтгүй ажиллуулсан.

Дизайн хөгжүүлэлтийн хувьд өнгөрөгч онд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн Монгол Улсад анхлан ноолууран гутлыг үйлдвэрлэн хэрэглэгчдийн гарт хүргэсэн. Мөн Ерөнхий дизайнераар Итали Улсын алдарт дизайнер Giorgio Spina ажиллан дэлхийн хэмжээний загварын шоуг Монголдоо амжилттай зохион байгуулж ноолууран бүтээгдэхүүний загварыг шинэ түвшинд хүргэсэн коллекцуудыг танилцуулав. Энэхүү үйл явдал нь Говь брэндийг дотоод болон гадаадын зах зээлийн хэрэглэгчдэд шинэ өнгө төрхтэйгөөр таниулж чадсан гэж бид үзэж байна.

Дээр дурдсан үр дүнд үндэслэн Говь ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг 2023 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж **Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.**

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

GOBI

MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, Компанийн дүрмийн 6.1.9.12 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зүгээс оруулсан санал болон 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалингийн бүтэц ба хэмжээг 2024 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн дараах байдлаар шинэчлэн тогтоосугай.

| № | ТУЗ-ийн гишүүдийн цалингийн бүтэц | | | Шинэчилсэн цалин /төгрөг/ |
|---|-----------------------------------|--|----------------------------------|---------------------------|
| 1 | Тогтмол цалин | Үндсэн цалин | Ердийн гишүүний үндсэн цалин | 1,400,000 |
| | | | Хараат бус гишүүний үндсэн цалин | 2,800,000 |
| | Нэмэгдэл цалин | ТУЗ-ийн даргын нэмэгдэл | 1,000,000 | |
| | | Хорооны даргын нэмэгдэл | 400,000 | |
| 2 | Оролцооны цалин | Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор | | 650,000 |

Хоёр. ТУЗ-ийн гишүүдийн тогтмол цалинг сар бүр, оролцооны цалинг Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоонд үндэслэн тооцож, улиралд нэг удаа олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА

GOBI

MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны
цалингийн төсвийг батлах тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, Компанийн дүрмийн 6.1.9.12 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:


Нэг. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны цалингийн төсвийг дараах байдлаар баталсугай.

/төгрөг/

| Агуулга | 2023 он | | 2024 он | |
|-------------------|--------------------|--------------------|------------|------|
| | Төсөв | Төсөв | Өөрчлөлт | |
| | | | төгрөг | хувь |
| Тогтмол цалин | 161,200,000 | 211,200,000 | 50,000,000 | 31% |
| Оролцооны цалин | 41,800,000 | 50,700,000 | 8,900,000 | 21% |
| НДШ | 30,450,000 | 30,118,500 | (331,500) | -1% |
| Нийт цалин | 233,450,000 | 292,018,500 | 58,568,500 | 25% |

Хоёр. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Цалин, урамшууллын хороонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА

GOBI

MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгон Г
томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4, Компанийн дүрмийн 6.1.9.8, 6.2.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг дуусгавар болгосугай.

Хоёр. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Дамбын ГЭРЭЛМАА
Алтангэрэлийн ЖАРГАЛМАА
Дамбийжавын ХҮРЭЛБААТАР нарыг;

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

Баатарсайханы АМАРСАЙХАН
Цагаачийн БААТАРСАЙХАН
Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД
Дашдаваагийн ХУЛАН
Нямаагийн МӨНХБАТ
Энхтөрийн ПҮРЭВЛХАМ нарыг тус тус 3 жилийн хугацаагаар сонгон томилсугай.

ХУРЛЫН ДАРГА  Д.ГЭРЭЛМАА